

*Мэдүүлэх*



"Ай Жээ Эй ЭйЧ-Аудит" ХХК

## **“ГОВИЙН ӨНДӨР” ХК**

---

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон  
Санхүүгийн аудитын тайлан

Улаанбаатар хот  
2023

## АГУУЛГА

КОМПАНИЙ МЭДЭЭЛЭЛ .....	2
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ЗАХИДАЛ .....	3
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ .....	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН .....	7
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН .....	8
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН .....	9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН .....	10
ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	11
ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ .....	11
ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ЗҮЙЛС .....	15
ТОДРУУЛГА 4. АВЛАГА .....	15
ТОДРУУЛГА 5. БАРАА МАТЕРИАЛ .....	15
ТОДРУУЛГА 6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ .....	15
ТОДРУУЛГА 7. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ .....	16
ТОДРУУЛГА 8. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР .....	16
ТОДРУУЛГА 9. ХУВЬЦААТ КАПИТАЛ .....	16
ТОДРУУЛГА 10. ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ .....	17
ТОДРУУЛГА 11. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО .....	17
ТОДРУУЛГА 12. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ .....	17
ТОДРУУЛГА 13. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ .....	17
ТОДРУУЛГА 14. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ .....	17

## КОМПАНИЙ МЭДЭЭЛЭЛ

Компаний нэр /Оноосон нэр/	Монгол	"Говийн өндөр" ХК
Компаний удирдлага	П.Батбаяр	Еренхий захирал
Компаний хаяг:	Монгол Улс,Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3-р баг Утас: (976)-70533388, 99118803	
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:	1110001003	
Регистрийн дугаар:	2016311	
Бүртгэгдсэн он сар	2006.12.26	
Үйл ажиллагааны чиглэл	Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэл	
Санхүү	Ш.Долгормаа	Еренхий нягтлан бодогч
Ажилчдын тоо	..... орчим ажилчидтай	
Аудитын компани	"Ай Жэй Эй ЭйЧ -Аудит" ХХК Нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын итгэмжлэгдсэн хендленгийн байгууллага	
Аудитын компаний хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Борх төв 301, 310 тоот. Утас: 976-11450279, Факс: 976-11-450279,	

## **2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлаах талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 5-6 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Говийн өндөр" Хувьцаат Компаний /Компани гэх/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгах үүднээс хийгдсэн болно.

Удирдлага нь компаний санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- ✓ Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдех
- ✓ Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- ✓ СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- ✓ Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг үйл ажиллагааны суурийг үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- ✓ Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловруулж, хэрэгжүүлж ажиллуулах
- ✓ Компаний санхүүгийн байдлыг аливаа хугацаанд үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хетлех
- ✓ Компаний нягтлан бодох бүртгэл хетлэлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- ✓ Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ✓ Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Говийн өндөр" ХК-ий 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон  
жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.



*П. Батбаяр*

П.Батбаяр  
Ерөнхий захирал

*Ш.Долгормаа*

Ш.Долгормаа  
Ерөнхий нягтлан бодогч



# “Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК

20.03.он.03.спр.20.одор

№ 44/2023

Улаанбаатар хот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Говийн өндөр” ХК-ний хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

“Говийн өндөр” ХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлзэс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, здгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Говийн өндөр” ХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Здгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлагаа гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

### Аудитын гол асуудлуууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хурзэнд здгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

### Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилууллахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдех, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх, тухайн нехцэл байдалд үндэслэлтэй тайлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тодруулсан ба цаашид компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг хүлээсэн байна.

### Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан здгэр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгэр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн швардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгэр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй хийхтэй холбоотойгоор, аудитор компаний дотоод хяналтын үр налаатэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нехцэл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компаний санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үзэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг өрөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Мен нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлсон.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компаний тухай хууль"-ийн 4-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Говийн өндөр" ХК-ний хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ай Жэй Эй Эйч Аудит ХХК  
Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2023.05.20

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

/мянган.төгрөгөөр/

2021 2022

## ХӨРӨНГӨ

### Эргэлтийн хөрөнгө

Монгол хөрөнгө	202,538.4	215,223.2
Авлага	276,618.4	285,982.6
Татвар, НДШ-ийн авлага	319.7	-
Бараа материал	118,930.8	69,811.3
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	2,230.0	2,230.0
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>600,637.3</b>	<b>573,247.1</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	290,030.8	276,284.7
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,000.0	5,000.0
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>295,030.8</b>	<b>281,284.7</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>895,668.1</b>	<b>854,531.8</b>

### ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

#### Богино хугацаат өр төлбөр

Татварын өглөг	103,062.3	154,299.1
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	1,380.2	2,706.2
Банкны богино хугацаат зээл	164,175.9	98,502.1
Урьдчилж орсон орлого	33,199.5	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>301,817.9</b>	<b>255,507.4</b>

#### Урт хугацаат өр төлбөр

#### Урт хугацаат зээл

#### Бусад урт хугацаат өр төлбөр

#### Урт хугацаат өр төлбөрийн дүн


<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>301,817.9</b>	<b>255,507.4</b>
------------------------------	------------------	------------------

### Эздийн өмч

#### Өмч / торийн /

#### Өмч / хувийн /

Хөрөнгийн дахин үнэлгээний иэмэгдэл	19,049.1	19,049.1
Гадаад хөрвүүлэлтийн неоц	341,552.7	341,552.7
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	2,601.0	2,601.0
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>230,647.4</b>	<b>235,821.6</b>
<b>Нийт өр төлбөр, өмчийн дүн</b>	<b>593,850.2</b>	<b>599,024.4</b>
	<b>895,668.1</b>	<b>854,531.8</b>



Измэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайллангийн сал明朗 хэсэг болно.

## ОРЛОГЫН ТАЙЛАН

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	2022
Борлуулалтын орлого	410,048.2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	205,996.9
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>204,051.3</b>
Ногдол ашгийн орлого	-
Бусад орлого	-
Борлуулалт маркетингийн зардал	197,746.6
Еронхий ба удирдлагын зардал	-
Санхүүгийн зардал	500.0
Бусад зардал	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны (гарз)	-
Бусад ашиг /алдагдал/	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>5,804.7</b>
Орлогын татварын зардал	630.5
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>5,174.2</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>5,174.2</b>
<i>Нэмээлт тооцруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салыгүй хэсэг болно</i>	

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
**2022 оны 12 сарын 31-ний одрийн байдалаар**

/мянган.төгрөгөөр/					
	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үзэлжлийн ицмогдэл	Гадаад ваалютын хөрвүүлэгчийн иөөн	Хуримтлагч- сан ашиг	Нийт дүн
<b>2021 оны 12 сарын 31</b>	<b>19,049.10</b>	<b>341,552.70</b>	<b>2,601.00</b>	<b>230,647.40</b>	<b>593,850.20</b>
Гаргасан хувьцаат капитал					-
Нягтлан болох бүртгэлийн бодлогын бөрчилгэвийн нэлээ, алдааны зарцуулга	19,049.10	341,552.70	2,601.00	230,647.40	593,850.20
Залзуулсан улдэгдэл					-
Тайлант үсүүн цэвэр ашиг аллагал					-
Бусад дэлгэрэнгүй орлого					-
<b>2022 оны 12 сарын 31</b>	<b>19,049.10</b>	<b>341,552.70</b>	<b>2,601.00</b>	<b>235,821.60</b>	<b>599,024.40</b>

*Нэмээн тооруулсандаа нь эдээсээр санхүүгийн тийшканчийн саламүй хэсэг болно.*

*Бүртгэлж хийвсэн  
бийгүйн тийшканчийн  
хэсэгийн хувьцаат*

# МОНГОН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

/мян.төгрөг/

2022

<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>336,458.00</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	336,458.00
Даатгалын иөхөврөөс хүлээн авсан мөнгө	
Бусад мөнгөн орлого	
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>263,599.40</b>
Ажилчдад талсан	23,504.80
Нийгмийн даатгалын байгууллагад талсан	46,910.30
Бараа материал худалдан авахад талсан	115,760.70
Ашиглалтын зардалд талсан	4,423.00
Түлш шатахуун, тээврийн хэлс, сэлбэг хэрэгсээд талсан	12,540.60
Хүүний төлбөрт талсан	
Татварын байгууллагад талсан	16,542.10
Даатгалын төлбөрт талсан	
Бусад мөнгөн зарлага	43,917.90
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>72,858.60</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,500.00</b>
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	5,500.00
Хүлээн авсан хүүний орлого	
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд талсан	
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд талсан	
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,500.00</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	
Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>65,673.80</b>
Зээл, ерийн үнэт цаасны төлбөрт талсан мөнгө	65,673.80
Ханшийн зерүүний гарз	
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(65,673.80)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>12,684.80</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	202,538.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	215,223.20

Нэмээтийн тодруулгууд нь эдэээр санхүүгийн тайллангийн салшгүй хэсэг болно.



## **ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

### **ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА**

"Говийн өндөр" ХК нь Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа явуулж байна.

Компани нь орлого ашгаа арвижуулах замаар хувьцаа зээмшигчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна. Үүнд:

- Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэл
- Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Хүнсний барааны жижиглэн худалдаа
- Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл

## **ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ**

### **2.1 Нягтлан бодох бүртгэлийн үндэс**

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт цаашид (СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол улсын зохих хууль, тогтоомжийг үндэслэн бэлтгэсэн.

### **2.2 Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют**

Компаний үйл ажиллагааны валют нь Монгол улсын үндэсний валют төгрөг юм.

### **2.3 Үнэлгээ**

Санхүүгийн тайланг түүхэн өргтийн зарчмаар бэлтгэдэг.

### **2.4 Нягтлан бодох бүртгэлийн суурь**

Компани нягтлан бодох бүртгэлийн аккурэль суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

### **2.5 Санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл**

Компани одоо болон алс ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

### **2.6 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дахь харилцах дансуудаас бүрдэнэ. Мөнгө түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэдэг,

### **2.7 Авлага**

Байгууллага, иргэдэд буцаан төлөгдөх нехцэлтэйгээр олгосон мөнгө, татвар, шимтгэлийн авлагыг бусад авлагаар бүртгэдэг. Эдгээр авлагыг тухайн үеийн

нэхэмжлэх дүнгээр тайлагнадаг. Авлагын хувьд насжилт, цуглуулагдах магадлалыг үнэлэн найдваргүй авлагын нөөцийн сан байгуулдаггүй.

## 2.8 Урьдчилж төлсөн зардал, тооцоо

Худалдан авах бараа, үйлчилгээний үнийн урьдчилгаа, дараагийн тайлант үед хамаарах зардлыг урьдчилж гарсан зардал, тооцоо дансанд бүртгэдэг. Урьдчилж төлсөн зардал, тооцоог тайлант үеийн холбогдох хөрөнгө, зардал дансдад хамаарна.

## 2.9 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ дээр түүнийг олж бэлтгэхэд гарсан зардал, капиталжуулсан засварын зардлыг нэмсэн дүнгээс бүрддэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүнийг ашиглалтанд орсон хугацаанаас эхэлж, хөрөнгийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож байгуулдаг.

Элэгдэл тооцох арга болон хугацаа нь Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн заалтад нийцэх бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн төрөл	ашиглагдах хугацаа (жилзэр)
Барилга, байгууламж	40
Уул уурхайн тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга, эд хогшил	10
Компьютер, дагалдах хэрэгсэл	2
Бусад хөрөнгө	10

Үндсэн хөрөнгөнд хийсэн урсгал болон их засварын зардлыг засвар хийх тухай бүр тооцож бүртгэнэ.

Засварын зардал нь үндсэн хөрөнгийн анхдагч үнэлгээний үед тогтоосон бүтээмжийг дээшлүүлэхүүц, компанийн хүртэх ирээдүйн здийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэхүүц, ашиглагдах хугацааг уртасгахаар байвал тэдгээрийг капиталжуулах ёстой. Бусад засварын зардлыг урсгал засвар гэх бөгөөд тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.

## 2.10 Биет бус хөрөнгө

Ажил үйлчилгээний нийлүүлэлтэд болон удирдлагын зориулалтаар ашиглахаар эзэмшиж байгаа биет шинж чанаргүй, харьцангуй удаан хугацаагаар ашиглагдах хөрөнгийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг хөрөнгийн ашиглагдах жилийг үндэслэн шулуун шугамын аргаар тооцдог.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг тооцох арга болон хугацаа нь Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн заалтад нийцэх бөгөөд биет бус хөрөнгийн хорогдуулга тооцох хугацаа дараах байдалтай байна.

Ангилал	Ашиглагдах хугацаа (жилзэр)
Программ хангамж	3
Ашиглагдах хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10
Ашиглагдах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө хүчин төгөлдөр байх хугацаа	

## 2.11 Татварын өглөг

Монгол улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын санд төлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

## 2.12 Банкны богино хугацаат зээл

Богино хугацаагаар буюу нэг жилээс доош хугацаанд төлөхөөр авсан зээлийг богино хугацаат өр гэж үзэж энэ хэсэгт тусгана.

## 2.13 Урьдчилж орсон орлого

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсвэл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж "Урьдчилж орсон орлого" дансанд бүртгэнэ.

## 2.14 Эзэмшигчдийн өмч

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчээс оруулсан хөрөнгө, хурийтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийлдэг.

Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дүн нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүн байна.

Хурийтлагдсан ашиг, алдагдал нь өмнөх болон тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

## 2.15 Орлого

Орлого нь хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

## **2.16 Үйл ажиллагааны зардал**

Компанийн удирдлагын болон үндсэн үйл ажиллагаанд хамаарах зардлыг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрөх ба үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ногдох дүнгээр нь бүртгэдэг.

## **2.17 Компанийн орлогын албан татвар**

Компани санхүүгийн жилийн татвар ногдуулах орлого, түүнд ногдуулсан орлогын албан татварыг Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн дагуу тодорхойлж тайлгагнадаг.

Тухайн хуулийн дагуу 6.0 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах жилийн орлогод, 10 хувиар, 6.0 тэрбум төгрөгээс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 600.0 сая төгрөг дээр 6.0 тэрбуунаас дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ногдуулж төлдөг.

## **2.18 Хувь хүний орлогын албан татвар**

Монгол улсын "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулиар компани ажиллагсад болон гэрээт ажилчдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоос 10 хувиар хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт төлөх үүрэг хүлээдэг. Мөн оршин суугч бус татвар төлөгчид шилжүүлсэн орлогоос "Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар"-ын тухай хуулийн дагуу 20 хувиар дундын суутгал хийдэг. Давхар татвар ноогдуулахаас зайлсхийх тухай Олон улсын хэлэлцээр бүхий улс орны оршин бус татвар төлөгчдийн хувьд энэхүү татварын түвшинг (0) хүртэл бууруулдаг.

## **2.19 Нийгмийн даатгалын шимтгэл**

Монгол улсын "Нийгмийн даатгалын тухай" хуулийн дагуу компани ажиллагсадад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын дүнгээс даатгуулагчаас 11.5 хувиар, ажил олгогчоос 12.5 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээдэг.

## **2.20 Нэмэгдсэн өртийн албан татвар**

Монгол улсын "Нэмэгдсэн өртийн албан татварын тухай" хуулиар нэмэгдсэн өртийн албан татвар (НӨАТ) ногдох бараа, ажил үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож НӨАТ төлдөг.

Мөн хуулиар НӨАТ ногдох бараа, ажил үйлчилгээний орлогын хэмжээ хуулийн этгээдийн орлогын албан татварын тайлангаар 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хурсэн ёдрийн дараа сараас НӨАТ төлөгчөөр бүртгүүлдэг.

Үндсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний борлуулалтын орлого 50.0 сая төгрөгт хурсэн эсэхээс үл хамааран Монгол улсад 2.0 сая амдоллар ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээд сайн дураараа НӨАТ төлөгч болно.

### ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ЗҮЙЛС

Тайлант хугацааны эцсээрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

	2021	2022
Кассад байгаа бэлэн мөнгө (төгрөг)	201,612.7	213,869.7
Бэлэн мөнгөний үлдэгдэл	<u>201,612.7</u>	<u>213,869.7</u>
Банкин дахь харилцах дансны үлдэгдэл	925.7	1,353.5
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн дүн	<u>202,538.4</u>	<u>215,223.2</u>

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, талбер гүйцэтгэх зориулалттай банкин дахь төгрөгийн болон долларын харилцах дансуудаас бурдсан байна.

### ТОДРУУЛГА 4. АВЛАГА

	2021	2022
Дансны авлага	276,618.4	285,982.6
ААНОАТ-ын авлага	319.7	-
Авлагын дүн	<u>276,938.1</u>	<u>285,982.6</u>

### ТОДРУУЛГА 5. БАРАА МАТЕРИАЛ

	2021	2022
Түүхий эд материал	118,930.8	69,811.3
Бараа материалын дүн	<u>118,930.8</u>	<u>69,811.3</u>

### ТОДРУУЛГА 6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

А. Үндсэн хөрөнгийн тайлант оны хөдөлгөөнийг харуулбал дараах байдалтай байна.

	2021	2022
Барилга байгууламж	383,592.5	383,592.5
Машин тоног төхөөрөмж	19,156.0	19,156.0
Тавилга эд хогшил	1,663.4	1,663.4
Үндсэн хөрөнгийн дүн	<u>404,411.9</u>	<u>404,411.9</u>

Б. Хуримтлагдсан элэгдэл

	2021	2022
Барилга байгууламж	105,481.8	117,709.0
Машин тоног төхөөрөмж	8,899.3	10,251.9
Тавилга эд хогшил	-	166.3
<b>Үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн</b>	<b>114,381.1</b>	<b>128,127.2</b>

#### ТОДРУУЛГА 7. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2021	2022
Урт хугацаат хөрөнгө оруулалт	5,000.0	5,000.0
<b>Урт хугацаат хөрөнгө оруулалтын дүн</b>	<b>5,000.0</b>	<b>5,000.0</b>

#### ТОДРУУЛГА 8. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

	2021	2022
ААНОАТ -ын өр		310.7
НӨАТ-ын өр	74,091.0	96,237.3
Онцгой албан татварын өр	24,655.0	55,466.1
ХХОАТ-ын өр	862.6	100.9
НДШ-ийн өвлөгөө	1,380.2	2,706.2
Богино хугацаат зээл	164,175.9	98,502.1
Урьдчилж орсон орлого	33,199.5	-
Бусад татварын өр	3,453.7	2,184.1
<b>Богино хугацаат өр төлберийн дүн</b>	<b>301,817.9</b>	<b>255,507.4</b>

#### ТОДРУУЛГА 9. ХУВЬЦААТ КАПИТАЛ

	2021	2022
Хувийн өмч	19,049.1	19,049.1
<b>Хувьцаат капиталын нийт дүн</b>	<b>19,049.1</b>	<b>19,049.1</b>

Компаний хувь нийлүүлсэн хөрөнгө нь 19,049.1 мянган төгрөг байна.

**ТОДРУУЛГА 10. ХУРИМТЛАГДСАН АШИГ /АЛДАГДАЛ/**

	2021	2022
Тайлант үеийн ашиг	230,647.4	235,821.6
<b>Хуримтлагдсан ашгийн дүн</b>	<b>230,647.4</b>	<b>235,821.6</b>

**ТОДРУУЛГА 11. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**

	2021	2022
Борлуулалтын орлого	128,430.0	410,048.2
<b>Борлуулалтын орлогын дүн</b>	<b>128,430.0</b>	<b>410,048.2</b>

**ТОДРУУЛГА 12. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ**

	2021	2022
Борлуулалтын өртөг	26,772.0	205,996.9
<b>Борлуулалтын өртгийн дүн</b>	<b>26,772.0</b>	<b>205,996.9</b>

**ТОДРУУЛГА 13. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ**

	2021	2022
Еренхий ба удирдлагын зардал	120,501.9	197,746.6
Бусад зардал	-	500.0
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>120,501.9</b>	<b>198,246.6</b>

**ТОДРУУЛГА 14. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ**

Тайлант хугацаанд 410,048.2 мянган төгрөгийн борлуулалтын орлого олж, 205,996.9 мянган төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцож, 198,746.6 мянган төгрөгийн зардал гарч, 5,804.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба 630.5 мянган төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхөөр тооцоологдсон байна.

Бэлтгэсэн:

Аудитор

Аудиторын туслах



Г.Энхмаа

Б.Жавзансүрэн